

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн цахим мөнгөний
үйлчилгээний журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг 2012 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний түр журам”-ыг хүчингүй болгосонд тооцсугай.
4. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6-д заасан цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны хүрээнд банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээ эрхлэхэд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс сэргийлэх, цахим мөнгөний үйлчилгээний хэлбэрийг оновчтой тодорхойлох, боловсронгуй болгох, оролцогч талуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах, цахим мөнгөний үйлчилгээнээс учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ноос Банк бус санхүүгийн байгууллагын эрхлэх тус үйлчилгээг зохицуулах, хяналт тавихад оршино.

1.2. Цахим мөнгөний үйлчилгээг Монголбанкнаас гаргасан цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн техник, програм хангамжийн шалгуур үзүүлэлтийг хангаж, дүгнэлт гаргуулсан, Хорооноос банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан Банк бус санхүүгийн байгууллага эрхэлнэ.

1.3. ББСБ нь банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээ эрхлэхдээ Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн Хорооноос болон холбогдох төрийн байгууллагуудаас баталсан бодлогын баримт бичиг, заавар, журмыг удирдлага болгоно.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Цахим мөнгө” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс нэхэмжилж болохуйц, төлбөр тооцоонд ашиглагдах бүрэн боломжтой, мөнгөний үнэ цэнэтэй зүйлийг хэлнэ. Цахим мөнгө нь дараах шинж тэмдгийг агуулна. Үүнд:

2.1.1.1. тусгай зориулалтын цахим төхөөрөмжид байрлах боломжтой;

2.1.1.2. бэлэн мөнгийг мөнгөн дүнтэй нь тэнцэх хэмжээний цахим мөнгөнд, шаардлагатай тохиолдолд бэлэн мөнгөнд буцаан хөрвүүлэх боломжтой;

2.1.1.3. үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдэх бөгөөд мөнгөн хадгаламж гэж үзэхгүй, хүү, урамшуулал бодогдохгүй.

2.1.2 “Цахим мөнгөний үйлчилгээ” гэж бэлэн мөнгийг цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан цахим мөнгөн хэлбэрт хөрвүүлэх, буцаан хөрвүүлэх, мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцоог түргэн шуурхай, баталгаатай гүйцэтгэх үйл ажиллагааг;

2.1.3. “Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч” гэж холбогдох төрийн байгууллагуудаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаж, дүгнэлт гаргуулсан, Хорооноос цахим мөнгөний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ-ыг;

2.1.4. “Цахим мөнгөний үйлчилгээнд оролцогч” гэж цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагчийг;

2.1.5. “Цахим хэтэвч эзэмшигч” гэж гар утас, *интернет* ашиглан цахим мөнгөний үйлчилгээг хэрэглэхээр үйлчилгээ эрхлэгчтэй гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

2.1.6. “Төлөөлөгч” гэж цахим мөнгөний үйлчилгээг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрт хүргэх, цахим хэтэвч эзэмшигчдийн бүртгэл болон бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээг гүйцэтгэх иргэн, хуулийн этгээдийг;

2.1.7. “Гэрээт хамтрагч” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж, өөрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг цахим хэтэвч эзэмшигчдэд цахим мөнгөөр борлуулж буй иргэн, хуулийн этгээдийг;

2.1.8. “ПОС терминал” гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс цахим мөнгөний төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор төлөөлөгч, гэрээт хамтрагчийн үйлчилгээний цэгүүдэд суурилуулсан, цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг хэлнэ;

2.1.9. “Дансны дугаар” гэж цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдын гар утасны дугаарыг хэлнэ.

ГУРАВ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг байна.

3.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цахим мөнгөний үйлчилгээг зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ.

3.3. Цахим мөнгөний үйлчилгээ нь бусдаас ялгарах өөрийн гэсэн оноосон нэртэй байна.

3.4. Цахим хэтэвч эзэмшигчийг эрсдэлээс хамгаалах, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах зорилгоор цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь дүрмийн сангийн 80 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний цахим мөнгийг төвлөрүүлнэ.

3.5. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь нийт цахим мөнгөний үлдэгдлийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний түргэн хөрвөх чадвар бүхий эргэлтийн хөрөнгөтэй байна. Эргэлтийн хөрөнгө нь бусад хэлбэрээр зарцуулагдахгүй ба дараах хэлбэртэй байна:

3.5.1. банкинд байршуулсан хадгаламж;

3.5.2. засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт.

3.6. Гэрээт хамтрагч болон төлөөлөгчийннэг удаад хийх гүйлгээний дээд хэмжээ 1,000,000.0 /нэг сая/ төгрөг, нэг өдөрт хийх гүйлгээний дээд хязгаар 5,000,000.0 /таван сая/ төгрөг байна.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 419 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.7. Цахим хэтэвч эзэмшигчийн нэг удаад хийх гүйлгээний дээд хэмжээ 1,000,000.0 /нэг сая/ төгрөг, нэг өдөрт хийх гүйлгээний дээд хязгаар 3,000,000.0 /гурван сая/ төгрөг байна.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 419 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.8. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь Хорооноос батлагдсан үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.

3.9. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь мэдээллийн технологийн боловсролтой, туршлагатай боловсон хүчнээр хангагдсан байна.

3.10. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь цахим хэтэвч эзэмшигчийн холбогдох мэдээлэл, нэгж дансны болон нэгтгэсэн балансад шаардагдах нарийвчилсан, бүрэн мэдээллийг агуулах, хөтлөх боломж бүхий мэдээллийн системтэй байна. Тус систем нь цахим мөнгөний хөдөлгөөнийг хянах, цахим хэтэвч эзэмшигчид болон цахим мөнгөний тоо хэмжээг тогтоох, цахим мөнгөний үйлчилгээнд оролцогч талуудын зөвшөөрсөн хэмжээнээс илүү гүйлгээ хийх, данс андуурсан зэрэг санамсаргүй үйлдлийг илрүүлэх, гүйлгээг зогсоох чадвартай байна.

3.11. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн өдрийн гүйлгээг тухайн өдрийн 00.00 цагаар тасалбар болгон тооцох ба үүнээс хойш хийгдсэн гүйлгээ нь дараа өдрийн гүйлгээнд тооцогдоно.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 419 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.12. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний журам, эрх, үүрэг, хариуцлагын талаар цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагч бүрт танилцуулан хамтран ажиллах гэрээг бичгээр үйлдэх бөгөөд үйлчилгээтэй хамааралтай үүсэх бүххариуцлагыг хүлээнэ.

~~3.13. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь толоологчтэй гэрээ байгуулахын өмнө дараах баримт бичгийг авсны үндсэн дээр гэрээ байгуулах шийдвэр гаргана. Үүнд:~~

—

~~3.13.1. ял шийтгэлтэй эсэх, залилан мэхлэх аливаа хууль бус үйлдэлд оролцож байсан эсэх талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт;~~

~~3.13.2. хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаарх Хорооны зээлийн мэдээллийн сангаас авсан лавлагаа;~~

/Энэ хэсгийг Хорооны 2012 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн 179 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 419 дүгээр тогтоолоор хассан/

3.13.3 мэргэжлийн хяналтын газраас гаргасан ажлын байрны дүгнэлт.

3.14. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь оролцогчдод лавлагаа, мэдээлэл өгөх, санал гомдлыг хүлээн авах байнгын утас, оператортой байх ба гомдол, саналыг барагдуулах тохиромжтой тогтолцоог бий болгож ажиллана.

3.15. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгөний үйлчилгээний системдараах өөрчлөлт хийхээс 30 хоногийн өмнө тухайн өөрчлөлттэй холбоотой саналаа холбогдох төрийн байгууллагад танилцуулж, дүгнэлт гаргуулан Хороонд албан ёсоор мэдэгдэнэ:

3.15.1. шинэ сувгуудыг ашиглан цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний цар хүрээг тэлэх /интернет хандалт, ПОС терминал гэх мэт/;

3.15.2. технологийг бэлтгэн нийлүүлэгч болон цахим мөнгөний үйлчилгээг дамжуулан хүргэх үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч өөрчлөгдөх;

3.15.3. үйлчилгээнд ашиглагдаж буй технологи, програм хангамж өөрчлөгдөх, нэмэлт шинэчлэлт хийх.

3.16. Системийн шинэчлэлттэй холбоотойгоос бусад өөрчлөлтийг хийсэн тухай бүр нь Хороонд албан ёсоор мэдэгдэнэ.

3.17. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн дотоод хяналтын систем нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.17.1. үйл ажиллагааны болон техник, технологийн горим, шаардлагыг хангасан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн;

3.17.2. техник, технологийн систем нь Монголбанкнаас тогтоосон шалгуурыг бүрэн хангасан, хэрэглээнд гарахаас өмнө 3 сараас доошгүй хугацаанд бүрэн туршигдсан;

3.17.3. Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон техникийн шалгуур үзүүлэлтийг хангасан.

3.18. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн эрх барих дээд байгууллагаас үйлчилгээний хэвийн, эрсдэлгүй ажиллагааг хангахтай холбоотой дараах бодлого, журам стандартыг батлан гаргаж, хэрэгжилтийг хангуулна. Үүнд:

3.18.1. дотоод хяналтын журам;

3.18.2. үйлчлүүлэгчдийн мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийн системд учирч болох гадаад, дотоод халдлагаас хамгаалах зэрэг асуудлыг багтаасан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах журам;

3.18.3. үйл ажиллагааны аюулгүй, хэвийн ажиллагааг хангах, гамшгаас сэргийлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх Эрсдэлийн удирдлага, үнэлгээний бодлого, стандарт.

3.19. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь өөрийн төлөөлөгч, гэрээт хамтрагчийн өмнөөс Хорооны өмнө хариуцлага хүлээнэ.

ДӨРӨВ. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч дараах эрхтэй:

4.1.1. цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдын нэрийн өмнөөс Хороотой харьцах;

4.1.2. цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдыг хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, биелүүлээгүйгээс учирсан хохирлыг барагдуулахыг шаардах, бүрэн арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

4.1.3. цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл гэнэтийн шалгалт хийх, хууль тогтоомж, гэрээний шаардлагыг хангаагүй нөхцөлд гэрээг цуцлах санал гаргах;

4.1.4. хууль хяналтын байгууллагаас оролцогчдын дансаар дамжин аливаа хууль бус гүйлгээ хийгдсэн тухай мэдэгдэл ирсэн тохиолдолд дансны зарлагын гүйлгээг зогсоох, данснаас хасалт хийх;

4.1.5. цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдоос үйлчилгээний ерөнхий нөхцөл,гэрээнд заасан үйлчилгээний шимтгэл авах.

4.2. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч дараах үүрэгтэй;

4.2.1. үйл ажиллагаандаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон Хороо, холбогдох төрийн байгууллагаас баталсан заавар, журмуудыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах;

4.2.2. эрх барих дээд байгууллагаас томилогдсон байнгын ажиллагаатай дотоод хяналтын бүтэцтэй, дотоод хяналт шалгалтыг тогтмол гүйцэтгэдэг байх;

4.2.3 цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчидтой Иргэний хууль, холбогдох бусад хууль болон энэ журамд нийцүүлэн эрх, үүрэг, хариуцлага, үйлчилгээний нөхцөл, цуцлах үндэслэл зэргийг тодорхой тусгасан гэрээ байгуулах;

4.2.4. цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагчийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөх, тэдгээрийн санал, гомдлыг ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэх зэрэг хяналтын тогтолцоо бий болгох;

4.2.5. энэ журмын 1, 2, 3 дугаар хавсралтын дагуу төлөөлөгч, гэрээт хамтрагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, цахим хэтэвч эзэмшигчдийн газар зүйн байршлаар гаргасан нэгтгэл, санхүүгийн тайлан, цахим мөнгөний гүйлгээний дэлгэрэнгүй мэдээ болон нэгтгэлийг энэ журмын хавсралтын дагуу сар бүр дараа сарын эхний 10-нд багтаан Хороонд ирүүлэх;

4.2.6.Хорооноос шаардсан мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх, Хорооны хянан шалгагч, шалгалтын ажлын хэсгийг ажлын байр болон мэдээллийн системд чөлөөтэй нэвтрүүлэх;

4.2.7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Хорооны “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар”-т заасны дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх;

4.2.8. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь өөрийн төлбөр тооцоо, бүртгэл, хяналтын системийн доголдолгүй ажиллагааг өөрөө хариуцах;

4.2.9. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь цахим мөнгөний үйлчилгээг дамжуулан хүргэх үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгчтэй Монгол улсын хууль тогтоомж, холбогдох эрх бүхий байгууллагуудаас гаргасан эрх зүйн акт, энэ журмын дагуу гэрээ байгуулан хамтран ажиллах;

4.2.10. харилцаа холбооны сүлжээний ачаалал, гэмтэлтэй холбоотойгоор цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдын гар утсанд гүйлгээний мэдээлэл очихгүй, хугацаа алдах зэргээс үүсэх аливаа эрсдэл, холбоотой хариуцлагыг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь бүрэн хариуцах;

4.2.11. төлөөлөгчийг шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, цахим мөнгөний үйлчилгээг иргэдэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлах;

4.2.12. цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдод үйл ажиллагаа, өөрчлөлт шинэчлэлтийн талаар заавар зөвлөгөө өгөх, сургалтанд тогтмол хамруулах;

4.2.13. гэрээт хамтрагч болон төлөөлөгч болохыг нотлосон ажлын байрны батламж, нэгэн ижил таних тэмдэг бүхий хаягжилт хийх, коджуулах;

ТАВ.ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Цахим хэтэвч эзэмшигч нь дараах эрхтэй байна:

5.1.1. гэрээний үндсэн дээр цахим мөнгөний үйлчилгээнд оролцох;

5.1.2. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны журамтай танилцах, өөрт холбогдох дансны хуулга болон мэдээллийг гаргуулах;

5.1.3. өөрийн цахим хэтэвчид хийгдсэн гүйлгээний талаарх мэдээллийг гүйлгээ хийгдсэн тухай бүр гар утсандаа мессеж хэлбэрээр хүлээн авах;

5.1.4. цахим мөнгөний үйлчилгээний гарын авлага авах, дуудлагын төв, үйлчилгээний вэб хуудсаар үйлчилгээний мэдээлэл авах, үйлчилгээний болон системийн өөрчлөлттэй холбоотой мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах;

5.1.5. цахим мөнгөний үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, лавлагааг цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгчийн лавлах утаснаас дурын үед авах боломжоор хангагдах, ПИН кодоо дурын үед солих;

5.1.6. хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тодорхой хугацаагаар үйлчилгээний эрхээ түр хаалгах, сэргээлгэх;

5.1.7. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчдээс шаардах.

5.2. Цахим хэтэвч эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ:

5.2.1. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид өөрт холбогдолтой мэдээллийг үнэн, зөв бүрэн өгөх;

5.2.2. цахим хэтэвч эзэмшигч нь ПИН код, нууц кодоо үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн дансанд эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн тухай мэдсэн, өөрийн данстай холбоотой бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дугагдлыг илрүүлсэн болон өөрийн нууц код болон бусадкодыг эрх олгогдоогүй гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй тухай сэжиглэж байвал нэн даруй ПИН код, нууц кодоо солих, цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;

5.2.3. энэ журмын 5.2.2-т заасан үүргийг биелүүлээгүйн улмаас болон биелүүлсэн ч хугацаа алдсанаасүүссэн хохирлыг цахим хэтэвч эзэмшигч хариуцна.

5.2.4. цахим хэтэвч эзэмшигч нь өөрийн цахим мөнгөний дансаа удирдахад ашиглагдах хэрэглэгчийн нэр, нууц код, ПИН код болон бусад мэдээллийн нууцлалыг хадгалах, өөрийн буруутай үйл ажиллагаанаас дансны дугаар, үнийн дүнг буруу оруулсан тохиолдолд хариуцлагыг өөрөө хүлээх;

5.3. Гэрээт хамтрагч нь дараах эрхийг эдлэнэ:

5.3.1. гэрээний үндсэн дээр цахим мөнгөний үйлчилгээнд оролцох, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж буй бусад үйлчилгээг авах;

5.3.2. өөрийн дансны үлдэгдэл болон гүйлгээний хуулгыг шаардлагатай үедээ цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс баталгаажуулан авах, үүнтэй холбоотой мэдээ, тайлбар авах;

5.3.3. хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тодорхой хугацаагаар үйлчилгээний эрхээ түр хаалгах, сэргээлгэх;

5.3.4. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс шаардах;

5.4. Гэрээт хамтрагч нь дараах үүргийг хүлээнэ:

5.4.1. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй хийсэн гэрээний үндсэн дээр цахим хэтэвч эзэмшигчийн төлбөрийг түргэн шуурхай хүлээн авах, бэлэн мөнгөөр тооцоо хийж буй үйлчлүүлэгчтэй ижил нөхцөлтэйгээр үйлчилгээг үзүүлэх, аливаа нэмэлт шимтгэл, хураамж авахгүй байх;

5.4.2. цахим хэтэвч эзэмшигчийн гомдол, саналыг хүлээн авч цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх, шийдвэрлэх;

5.4.3. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид өөрт холбогдолтой мэдээллийг үнэн, зөв бүрэн өгөх;

5.4.4. дансны дугаар өөрчлөгдсөн, ПИН код, нууц кодоо үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн дансанд эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн тухай мэдсэн, өөрийн данстай холбоотой бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн болон өөрийн ПИН код, нууц код болон бусад кодыг эрх олгогдоогүй гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй тухай сэжиглэж байвал нэн даруй ПИН код, нууц кодоо солих, цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;

5.4.5. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч, цахим хэтэвч эзэмшигчдийн төлбөр тооцоотой холбоотой аливаа мэдээ, мэдээллийн нууцыг чандлан сахих;

5.4.6. хаяг байршил болон үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид ажлын 5 өдрийн дотор мэдэгдэх;

5.4.7. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд нөлөөлөх аливаа асуудал үүссэн тохиолдолд цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;

5.5. Төлөөлөгч нь дараах эрхийг эдлэнэ:

5.5.1. энэ журмын 5.3 дахь хэсэгт заасан эрх нэгэн адил хамаарна.

5.5.2. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс үйлчилгээний ерөнхий нөхцөл, гэрээнд тусгасны дагуу төлөөлөгчийн үйлчилгээ үзүүлсний шимтгэл, урамшууллыг нэхэмжлэх.

5.6. Төлөөлөгч нь дараах үүргийг хүлээнэ:

5.6.1. энэ журмын 5.4 дахь хэсэгт заасан үүрэг нэгэн адил хамаарна.

5.6.2.цахим хэтэвч эзэмшигч, гэрээт хамтрагчийн хүсэлтээр бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх, цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх;

5.6.3. үйлчилгээг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс батлан гаргасан зааврын дагуу түргэн шуурхай үзүүлэх;

5.6.4. бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээг хийхдээ харилцагчдын дансны дугаар болон мөнгөн дүнг, нууцлалын кодыг зөв оруулах;

5.6.5.төлөөлөгчийн дансаар гүйлгээ хийхэд ашиглагдах пин код болон нууц үгийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, бусдад мэдэгдэхгүй байх, сэжиг бүхий нөхцөлд ПИН код, нууц кодыг тухай бүр сольж байх;

5.6.6.төлөөлөгчийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бэлэн мөнгөний нөөц, түүний хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалтай холбогдон үүсэх асуудлыг бүрэн хариуцах;

5.6.7.ажлын байрандаа цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс олгосон таних тэмдэг бүхий батламж, дансны дугаар, үйлчилгээний үнийн саналыг харилцагчдад харагдахуйц ил газар байрлуулах;

5.6.8. орлого, зарлагын гүйлгээний баримтыг гүйлгээ тутамд үйлдэн бүртгэх, баримтыг нэг жилээс доошгүй хугацаанд архивлан хадгалах;

5.6.9.цахим хэтэвч эзэмшигчийн бүртгэлийг үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх;

5.6.10.цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс баталж гаргасан журмын дагууцахим дансандаа заавал байлгах мөнгөн дүнг байршуулсан байна.

ЗУРГАА. ЦАХИМ ХЭТЭВЧ ЭЗЭМШИГЧДИЙГ ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ

6.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн техник, програм хангамжийн шалгуур үзүүлэлтийг Монголбанк, харилцаа холбооны техникийн шалгуур үзүүлэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороо тогтооно.

6.2.Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийг Хорооны зөвшөөрөлгүйгээр санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

6.3. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь гүйлгээ хийх, хийгдсэн гүйлгээнд залруулга хийхэд давхар хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна. Гүйлгээ хийх эрх бүхий ажилтан болон удирдах ажилтныг “мэргэжлийн хариуцлагын даатгал”-д хамруулна.

6.4. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь хийгдэж буй гүйлгээ бүрт тухайн гүйлгээнд холбоотой цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчид болон орлого хүлээн авагчид мессежээр мэдээлэл өгөх техник, технологийн боломжийг хангана.

~~6.5. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь учирч болзошгүй аливаа эрэдлээс хамгаалах зорилго бүхий эрэдлээс хамгаалах санг цахим мөнгөнд хөрвүүлсэн нийт дүнгийн 15%-иас доошгүй хэмжээтэй тэнцэх дүнгээр байгуулж, тусгайлан байршуулна.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 419 дүгээр тогтоолоор хассан/

6.6. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь цахим хэтэвч эзэмшигч, гүйлгээ хариуцсан ажилтны санамсар болгоомжгүй байдлаас үүдэн хийгдсэн буруу гүйлгээг шуурхай залруулах, үүсэх хор хохирлоос сэргийлэх, багасгахад чиглэсэн арга хэмжээг журмаар зохицуулна.

6.7. Төлөөлөгч нь өдөрт хийх гүйлгээний эрхийн 20%-тай тэнцэх хэмжээний баталгаа(барьцаа)-г цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн дансанд байршуулсан байна. Төлөөлөгч нь үйлчилгээг эрхлэхдээ цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу олгогдсон кодыг тусгасан орлого, зарлагын баримтыг ашиглана.

/Энэ заалтыг Хорооны 2012 оны 6 дугаар сарын 179 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

6.8. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь системийг гадны халдлага, кибер гэмт хэрэгт өртөхөөс хамгаалсан тогтолцоог бүрдүүлнэ.

6.9. Банкнаас бусад цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хяналт шалгалтыг шаардлагатай гэж үзвэл Монголбанктай хамтарч гүйцэтгэнэ.

6.10. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь байгалийн аливаа гамшиг, болзошгүй халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор серверийг өөрийн байгууллагаас гадна өөр газар давхар байршуулж, тогтмол ажиллагааг хангана.

6.11. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь гэрээт хамтрагч, төлөөлөгч, цахим хэтэвч эзэмшигчдийн цахим мөнгөний үйлчилгээний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэхтэй холбогдуулан жил тутамд нэгээс доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.

6.12. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний болон системийн өөрчлөлттэй холбоотой мэдээллийг өөрчлөлт гарсан тухай бүр, хэвлэмэл болон өөрийн вэб хуудас, цахим шуудан, мессеж зэрэг хэлбэрээр цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдод өгч байна.

ДОЛОО. ЦАХИМ МӨНГӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

7.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч Банк бус санхүүгийн байгууллагад дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

7.1.1 цахим төлбөрийн хэрэгсэлд байршуулсан мөнгөн хөрөнгийг цахим хэтэвч эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр гүйлгээнд оруулах;

7.1.2. цахим мөнгийг нэрлэсэн үнээс хямдруулах болон нэмэгдүүлэх;

7.1.3. цахим хэтэвч эзэмшигч, төлөөлөгч, гэрээт хамтрагчийн нууцыг Монгол улсын хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээдээс бусад этгээдэд задруулах;

7.1.4. төлөөлөгч нь төлөөлөгчийн үйл ажиллагааны шимтгэл урамшууллаас гадна цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчоос ямар нэгэн шимтгэл, хураамж, түүнтэй адилтгах бусад шан харамж авах.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд санхүү, төлбөрийн эрсдэл үүсэх магадлалтай болсон нөхцөлд Хорооноос дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

8.1.1. цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавих;

8.1.2. бэлэн мөнгийг цахим мөнгөнд нэмж хөрвүүлэхийг хориглох;

8.1.3. үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох.

8.2. Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч нь энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээхээргүй бол хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулах болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

*“Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний
журам”-ын 1 дүгээр хавсралт*

..... ББСБ ХХК-ИЙН ГЭРЭЭТ ХАМТРАГЧИЙН БҮРТГЭЛ¹

20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн байдлаар

№	Гэрээг хамтрагчийн нэр	Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан огноо	Этгээдийн		Хаяг	Гүйцэтгэх удирдлагын		Тайлбар*
				Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар/ Иргэний үнэмлэхний дугаар		Овог нэр	Утас	

¹ Урьд мэдээнд тайлагнасан гэрээт хамтрагч хасагдаагүй тохиолдолд дахин тайлагнах шаардлагагүй
* Шинээр нэмэгдсэн эсвэл хасагдсан гэрээт хамтрагчийн талаарх дэлгэрэнгүй тайлбар

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: /Овог, нэр/ *тамга*

НЯГТЛАН БОДОГЧ: /Овог, нэр/

20__оны__сарын__ өдөр

“Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам”-ын 2 дугаар хавсралт

..... ББСБ ХХК-ийн ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ¹

20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн байдлаар

№	Төлөөлөгчийн нэр	Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан огноо	Этгээдийн		Хаяг	Гүйцэтгэх удирдлагын		Тайлбар*
				Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар/ Иргэний үнэмлэхний дугаар		Овог нэр	Утас	

¹ Урьд мэдээнд тайлагнасан гэрээт хамтрагч хасагдаагүй тохиолдолд дахин тайлагнах шаардлагагүй

* Шинээр нэмэгдсэн эсвэл хасагдсан төлөөлөгчийн талаарх дэлгэрэнгүй тайлбар

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: /Овог, нэр/ *тамга*

НЯГТЛАН БОДОГЧ: /Овог, нэр/

20__оны__сарын__ өдөр

“Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам”-ын 3 дугаар хавсралт

..... ББСБ ХХК-ИЙН ЦАХИМ ХЭТЭВЧ ЭЗЭМШИГЧИЙН БҮРТГЭЛ

20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн байдлаар

№	Хот, аймаг, сум, дүүргийн нэр	Цахим хэтэвч эзэмшигчийн тоо			
		Өмнө байсан	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Нийт

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: /Овог, нэр/ *тамга*
НЯГТЛАН БОДОГЧ: /Овог, нэр/

20__оны__сарын_ны_өдөр

“Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний
журам”-ын 4 дүгээр хавсралт

“..... ББСБ” ХХК-ИЙН ЦАХИМ МӨНГӨНИЙ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн байдлаар

№	Цахим хэтгэвч эзэмшигчдийн тоо/өссөн дүнгээр/	Хөрвүүлсэн мөнгөний дүн						Цахим мөнгөний үлгэдэл дүн /төгрөгөөр/	Дүрмийн сан /төгрөгөөр/	Түргэн хөрвөх хөрөнгийн дүн /төгрөгөөр/	Үүнээс		Эрдэлээс хамгаалах сан /төгрөгөөр/
		Цахим мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний тоо	Цахим мөнгөнд хөрвүүлсэн мөнгөн дүн /төгрөгөөр/	Бэлэн мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний тоо	Бэлэн мөнгөнд хөрвүүлсэн мөнгөн дүн /төгрөгөөр/	Цахим мөнгөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний тоо	Цахим мөнгөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний дүн /төгрөгөөр/				Банкинд байршуулсан хадгаламж	Засгийн газрын үнэт цаас	

тамга

..... /Овог, нэр/

..... /Овог, нэр/

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

НЯГТЛАН БОДОГЧ:

20__оны__сарын__-ны өдөр